

ӨГҮҮЛЭЛ

**“Нэг бүс Нэг зам” санаачилга ба Монгол Улс:
Шинжээчдийн судалгааны үр дүн****Ойдовын Хатанболд** 

Доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн,

Улаанбаатар, Монгол Улс

khatanboldo@mas.ac.mn

Хураангуй: Монгол Улс 1990 онд төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу шилжих үйл явц өрнөж нийгмийн тогтолцоо эрс өөрчлөгдсөн тухайн үеэс хойш ардчиллын замыг сонгон хөгжөөд гуч гаруй жилийн хугацааг туулж өнгөрөөв. Энэ хугацаанд Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн хөгжлийн талаарх олон арван судалгаанд тодорхой үнэлэлт, дүгнэлтүүдийг хийж ирсэн нь бий. Энд танилцуулж буй өгүүллийн хувьд Монгол Улсын хөгжил, онцлогийн талаар, мөн БНХАУ-ын санаачилгаар өрнөж буй “Бүс ба зам санаачилга”-д Монгол Улс хэрхэн оролцох, түүний үр өгөөж, нийгмийн өнөөгийн амьдралд хэрхэн тусгалаа олж буй хийгээд өмнө тулгарч буй саад бэрхшээл, гарц шийдлийг тодруулахыг зорив. Энэхүү өгүүллийг ерөнхий үндэслэл, нөхцөл байдал-шалтгаан, гарц-шийдэл ба дүгнэлт гэсэн дөрвөн үндсэн багцад ангилан судалгааны үр дүнг танилцуулж байна.

Түлхүүр үгс: Монгол Улс, БНХАУ, Бүс ба зам санаачилга, шинжээчид, уламжлал, үнэлгээ

Ерөнхий үндэслэл, нөхцөл шалтгааныг тодорхойлохуй


Монголчуудын уламжлалт улс төрийн үнэт зүйлсийн нэг чухал зүйл бол тэдний уламжлалт нүүдлийн соёл, түүний онцлог мөн чанар юм. Эдүгээ цагт монголчуудын уламжлалт нүүдлийн соёл нь суурин соёлын хүчтэй түрэлтэд орж, нийслэл Улаанбаатар хотдоо хүн амын бараг тал хувь нь¹

¹ 2022 оны байдлаар Улаанбаатар хотод 1596.3 иргэн буюу нийт иргэдийн 45 хувь нь оршин суудаг. <http://ubstat.mn/StatTable=20>



ажиллаж амьдарсаар буй монголчуудын өнөөгийн улс төрийн хандлага, үндэсний үзлийн талаарх орчин үеийн монголчуудын сэтгэлгээний өөрчлөлт нь хувьслын сонирхолтой үедээ ороод тодорхой хугацаа өнгөрч² буйг илтгэнэ. Эл онцлог нь монголчуудын үндэсний адилсал, өвөрмөц онцлог бүхий улс төрийн соёлыг бүрдүүлэх нэг чухал суурь болно. Түүхийн хуудснаа, монголчууд XVI, XVII зууны үед төвд хэлт буддын мэдлэгийг шууд

төвд хэлээр нь хүлээн авч өөрсдийн сэтгэлгээний онцлогийн үүднээс боловсруулж хөгжүүлснээр монголын нийгэмд буддын мэдлэг ухаан өргөн цар хүрээг хамран тэлж, оюун санааны бүхий л түвшинд гүнзгий нэвтрэх хөрс суурь болон бүрдэж чаджээ. Эндээс монголчуудын уламжлалт ба модерн шинжийн зохицолтой холбогдох онол, үзэл баримтлалын хандлага илрэх³ болно.



Өнөөгийн улс орны хөгжилд хэр зэрэг сэтгэл ханамжтай байгааг 1-10 оноогоор үнэлүүлсэн бөгөөд 1-5 тоо «маш муу, сэтгэл хангалуун бус» харин 6-10-ын тоо «маш сайн, сэтгэл хангалуун» гэсэн хэмжүүрээр шинжээчдээс тодруулав. Дурдсан

агуулгын хүрээнд судалгаанд хамрагдсан шинжээчдийн дийлэнх олонх буюу 75.5 хувь нь «сэтгэл хангалуун бус», 24.5 хувь нь «сэтгэл хангалуун» буюу дундаас ялимгүй дээш 6 оноогоор тус тус үнэлсэн болно.

Маш муу, сэтгэл хангалуун бус					Маш сайн, сэтгэл хангалуун				
1	2	3	4	5	6	7	8	9	10


Ийнхүү үнэлэх болсон шалтгаан нь хэт их төвлөрөл, улс төрийн хараат байдал, эдийн засгийн чадамж,

чадавхыг тэлэх төр засгийн бодлогын уялдаа холбоо сул байгаатай холбоотой.

² ШУА. Философийн хүрээлэн. Зүүн Европын улс орнууд болон монголын ардчилал: ололт, амжилт, сорилт бэрхшээл. ОУЭШХ. Илтгэлийн эмхэтгэл. УБ., 2022. 8-9 дэх тал

³ О.Хатанболд. Монгол Улс дахь шашны хэтийн хандлага. Эрдэм шинжилгээний хэлэлцүүлэгт хэлэлцүүлсэн илтгэл. ЕТГ., ҮАБЗ. Төрийн ордон, УБ., 2018 оны 4-р сарын 17-ны өдөр.

Зураг 1. Монгол Улсын хөгжилд хэр зэрэг сэтгэл ханамжтай эсэх талаарх шинжээчдийн үнэлгээ



Дурдсан шалтгааныг арилгахын тулд улс орны хэтийн хөгжил ямар салбар дээр тулгуурлан хөгжих боломжтой эсэхийг дараах байдлаар тодруулав. Ингэхдээ судалгаанд


хамрагдсан референт бүлгийнхний дэвшүүлсэн саналд шинжилгээ хийж хамгийн түгээмэл давтагдсан илэрхийлэмжүүдийг дараах байдлаар танилцуулж байна.



Дээрх үйл явцыг үндэслэл болгон өнөөгийн Монгол Улсын хөгжлийг хөрш орнуудын хөгжлийн хурдтай уялдуулах боломжийг оролдов. Ингэхдээ шинжээчдээр хамгийн чухал

гэж үзсэн 3 салбарыг нэрлүүлэхэд боловсрол (57.4%), үйлдвэрлэл (49.2%), мал аж ахуй (47.5%) хэмээн тус нэрлэснийг энд багцлан харуулав (Зураг 2).

Зураг 2. Монгол Улсын хөгжил ямар салбар дээр суурилах нь илүү үр өгөөжтэй болохыг тодруулсан байдал



Дээрх зурагт Монгол Улсын хөгжил ямар салбарт суурилсан тохиолдолд хурдацтай хөгжих боломжтойг харуулсан. Тэгвэл бидний дараагийн харьцуулсан зүйл бол найрсаг харилцаатай улс орнуудын хөгжлийн өнөөгийн нийгмийн амьдралын үйл явцад монголчууд бусад улсуудад хэр зэрэг найрсаг харилцаатай байдагт ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг тодруулах явдал байв. Шинжээчдээр үнэлүүлсэн энэхүү хандлагаас дундаж индексийг тооцвол шинжээчдийн дийлэнх нь ОХУ, Өмнөд Солонгос, Энэтхэг, Турк зэрэг орнуудыг 4.92 ± 4.97 оноогоор үнэлсэн бол, БНХАУ-ыг 3.69 оноогоор үнэлжээ (Хүснэгт 1).

Тэгвэл, Монгол Улс, БНХАУ-ын хооронд 1949 оны 10-р сарын 16-ны өдөр дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр орны харилцаа зарим нугарал бүдрэлийг өнгөрөөсөн боловч найрсаг хөршийн харилцаа нь гол шугам болсоор ирсэн. Хоёр орны хооронд нөхөрсөг хамтын ажиллагааны гэрээ 1994 онд Улаанбаатарт батлагдсан нь

хоёр орны харилцааг сайжруулах чухал алхам болсон ба хоёр улс хоорондын харилцаагаа 2003 онд харилцан итгэлцэлд суурилсан нөхөрсөг хөршийн харилцаа хэмээн тодорхойлсон. Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газруудын хамтарсан худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны ажлын хэсэг 1991 оноос хойш тогтмол уулзалт зохион байгуулах замаар худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг ханган ажилласаар ирсэн түүхтэй.

Үүнээс дараах дүгнэлтийг хийж болох юм. Тухайлбал, монголчуудын өнгөрсөн нийгмийн далан жилийн турш Оростой илүү дотно харилцаатай явж ирсэн түүхтэй бөгөөд ардчилалд шилжсэн эхний он жилүүдэд хоёр улсын харилцаа нэлээд суларсан. Гэвч ОХУ нь монголчуудын хувьд илүү эерэг дүр төрхтэй байсаар байна. Сүүлийн гуч гаруй жилийн хугацаанд монголчууд гадагш явах урсгал их эрчимтэй байж, дэлхий дээр хүрээгүй газар ховор төдийгүй монголчууд анх

очиж буй газар бүртээ соёлын ялгааны улмаас соёлын шоктой тулгарч, амьдарч, боломж гарвал ах дүү, танил талаа татаж тухайн улсад суурьших хандлага⁴ нийтлэг байна.

Улс орны хөгжил тааруу байгааг хөгжлийн төлөөх ид тод, нээлттэй, хариуцлагатай түншлэл дутмаг байгаатай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, тогтвортой хөгжил, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тогтвортой ардчилсан засаглалыг бэхжүүлэх нь нэн чухал. Энэ хүрээнд төрийн албыг боловсролтой, мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчнээр бүрдүүлж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх учиртай. Энэ нь төрийн бүх

шатны байгууллагуудын удирдлагын манлайлал, ил тод байдал, хариуцлагыг өндөрсгөх, улс төрийн тогтвортой байдлыг хангах, хууль дээдлэх зарчмыг бүх нийтээрээ дагаж мөрдөх, шийдвэр гаргах үйл явцад талуудын оролцоог нэмэгдүүлэх, олон нийтийн дуу хоолойг сонсох, засгийн газрын үйл ажиллагааны үр нөлөө, зохицуулалтын чанарыг сайжруулж, авлигыг арилгах сорилтууд тулгарсаар байна.

Тэрхүү сорилтыг өнөөгийн нийгмийн амьдралыг судлахад монголчууд бусад улсуудад хэр зэрэг найрсаг харилцаатай байдаг хийгээд үүнд ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг дараах байдлаар тодруулсныг танилцуулж байна.

Хүснэгт 1. Улс орнуудын талаар ямар санаа бодолтой байгааг тодруулсан шинжээчдийн үнэлгээ, хувиар

№	Улс орон	Маш эерэг (6)	Эерэг талдаа (5)	Бага зэрэг эерэг (4)	Бага зэрэг сөрөг (3)	Сөрөг талдаа (2)	Маш сөрөг (1)	Хэлж мэдэхгүй (0)	Дундаж (1-6)
1	Хятад	3.5	16.7	26.0	21.0	17.5	9.4	5.9	3.69
2	Казакстан	2.5	16.4	35.5	19.9	5.6	1.4	18.8	4.80
3	Орос	18.5	45.9	23.9	4.7	1.6	0.6	4.8	4.97
4	Солонгос	13.4	38.4	30.3	7.1	2.1	0.3	8.3	4.94
5	Энэтхэг	4.4	16.2	36.0	15.6	6.2	1.4	20.3	4.94
6	Турк	6.2	18.3	34.6	15.7	5.7	1.2	18.4	4.92

Эх сурвалж: “Евроазийн бүс нутаг дахь Монгол, Оросын соёл иргэншлийн харилцан үйлчлэл” хамтарсан төслийн хүрээнд хийгдсэн шинжээчдийн судалгаа. УБ., 2022

Манай орон бусад улсууд, ялангуяа Евроази тивийн орнуудтай ямар талбарт хамтран ажиллавал илүү амжилтад

хүрэх боломжтой эсэхийг шинжээчдээр үнэлүүлж, үр дүнг нэгтгэв. Чингэхэд, тэдний дийлэнх нь аж үйлдвэрлэл,

⁴ ШУА. Философийн хүрээлэн. Евроазийн бүс нутаг дахь Монгол, Оросын соёлын иргэншлийн харилцааны үйлчлэл. Хамтын бүтээл. ред. Г.Чулуунбаатар, А.С.Железняков, О.Хатанболд. Соёмбо принтинг ХХК. УБ., 2023. 272-273 дахь тал

малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулалт, боловсрол, аялал жуулчлалын салбаруудад илүү үр өгөөжтэй, харилцан ашигтай хамтын ажиллагааг зорилго болгон хөгжүүлэх шаардлага буйг харуулсан юм (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Евроазийн нутаг дэвсгэрт Монгол Улс ямар чиглэлийг илүү баримжаалж ажиллавал зохистойд шинжээчдийн өгсөн үнэлгээ

№	Салбар	Хувь	№	Салбар	Хувь
1	Аж үйлдвэрлэл	13.6	9	Зам тээвэр	6.4
2	Хөдөө аж ахуй	11.1	10	Жирийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт, худалдаа наймаа	4.5
3	Малын гаралт бүтээгдэхүүний боловсруулалт	14.1	11	Олон улсын байгууллагад хамтран ажиллах	4.4
4	Соёл урлаг	5.4	12	Түүх, музейн хамтын ажиллагаа	2.3
5	Шинжлэх ухаан	7.5	13	Хүүхэд залуучуудын арга хэмжээ, уралдаан тэмцээн	3.0
6	Боловсрол	11.2	14	Засаглал	2.0
7	Спорт	3.1	15	Аялал жуулчлал	8.6
8	Цэрэг армийн талбар, энхийг сахиулах үйл ажиллагаа	2.6			

Эх сурвалж: “Евроазийн бүс нутаг дахь Монгол, Оросын соёл иргэншлийн харилцан үйлчлэл” хамтарсан төслийн хүрээнд хийгдсэн шинжээчдийн судалгаа. Уб., 2022

“Евроазийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэл” (2020-2023) сэдэвт хамтарсан төслийн хүрээнд Монгол Улсын найрсаг хөршийн харилцаатай орнуудын байр суурийг тодруулсан байна. Чингэхэд шинжээчдийн дийлэнх нь “*ашигтай тал дээр хамтран ажиллах*” (51.3%), “*эвсэг эелдэг, бусдыг хүндэтгэн харьцах*” (51.3%), “*зөвхөн өөрийн орны эрх ашгийг урьтал болгох*” (9.8%) зэрэг нь найрсаг хөршийн харилцааг бэхжүүлэхэд илүү үр өгөөжтэй алхам

хэмээн үзсэн байна. Үүнээс монголчууд Евроазийн орнуудтай хэр зэрэг найрсаг харилцаатай хэмээн үзэж буйг тодруулан дундаж индекс боловсруулан гаргахад дараах дүр зураг ажиглагдлаа. Тухайлбал, монголчуудын хувьд Ерөнхийлөгчийн түвшинд дурдсан улс орнуудтай илүү үр дүнтэй харилцааг бэхжүүлж чадаж байна хэмээн үзжээ. Харин иргэд, орон нутгийн түвшинд эл найрсаг харилцаа харьцангуй бага түвшинд буй хэмээн нэрлэсэн (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Монголчууд Евроази тивийн ОХУ, Хятад, Турк зэрэг орнуудтай ямар түвшинд илүү үр дүнтэй харилцаж болох талаар шинжээчдийн өгсөн хариулт

№		Маш сайн (5)	Сайн (4)	Дунд (3)	Үр дүн гааруу (2)	Үр дүн алга (1)	Хэлж мэдэхгүй (0)	Дундаж (1-5)
1	Засгийн газар	6.0	31.8	32.5	10.2	3.9	15.7	4.20
2	Ерөнхийлөгч	8.0	29.6	29.7	10.6	4.6	17.5	4.31
3	УИХ	4.4	21.0	35.4	15.8	6.2	17.1	4.05
4	Орон нутагт	1.1	8.8	29.2	27.6	15.2	18.2	3.62
5	Иргэдийн түвшинд	1.5	8.8	25.1	24.7	20.6	19.2	3.61
6	Байгууллагуудын хооронд	2.3	13.0	26.1	18.9	15.1	24.6	4.16

Эх сурвалж: “Евроазийн бүс нутаг дахь Монгол, Оросын соёл иргэнийн харилцан үйлчлэл” хамтарсан төслийн хүрээнд хийгдсэн шинжээчдийн судалгаа. УБ., 2022

Хүснэгтээс харвал, орон нутгийн болон иргэдийн түвшинд үр дүнтэй харилцах байдлын индекс 3.61 ± 3.62 хооронд хэлбэлзэж байна. Тухайлбал, дурдсан үйл ажиллагааг илүү үр дүнтэй харилцах боломжийг бүрдүүлэхийн тулд юуны өмнө аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, визний асуудлыг шийдэх, дипломат харилцааг сайжруулах, аж үйлдвэрийг нэмэгдүүлэх (21.9%) нь судалгааны дүнгээр илэрсэн болно.

Эндээс дараах дүгнэлтийг хийж болох юм. Тодруулбал, иргэд улс

орны хөгжлийн ирээдүйг монгол орны үндэсний болон ахуйн соёлын онцлогуудтай уялдуулахыг чухалчилж байгаа нь харагдав. Ялангуяа орон нутгийн түвшинд тухайн бүс орон нутгийг хөгжүүлэх хүрээнд иргэдийн амьдрах орчин, оюунлаг байдалд өөрчлөлт оруулахуйц хэмжээний харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх нь найрсаг харилцаатай улс орнуудтай нэн тэргүүнд ойлголцох суурь алхам болсныг илтгэнэ.

Гарц, шийдэл

Аливаа улс орнуудын харилцан хамтын ажиллагаа түүний дотор зорилтод хөгжлийн төлөөх томоохон төслүүд, олон талт хамтын ажиллагааг өргөн хүрээнд үр өгөөжтэй, харилцан ашигтай, ил тод, хариуцлагатай амжилттай хэрэгжүүлэхэд тухайн оролцогч талуудын бодлого хийгээд институтүүдийн тогтвортой тодорхой байдал, иргэд, олон нийтийн итгэл найдвар, салбар хоорондын харилцан уялдаатай итгэлцэл, үр нөлөөнөөс

шууд хамаардаг. Энэ хамаарал нь улс орнуудын эдийн засгийн хөгжлийн төлөөх чадамжтай эдийн засгийг бүрдүүлэхэд зайлшгүй чухал шаардлагатай үнэт зүйлсээр хэмжигдэнэ. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн цаана улс төр (гэрээ, амлалт), соёл (үндэсний үнэт зүйлс, хэм хэмжээ, зан үйл, соёл урлаг, ёс заншил, түүх соёл)-ыг тооцохгүйгээр улс орнуудын институтүүдийн үр нөлөө бүхий тогтвортой үйл ажиллагаа,

иргэд олон нийтийн итгэлцэл, харилцан ашигтай эдийн засгийн уян хатан бодлого, түүний тасралтгүй тогтвортой хөгжих өсөлтийг бүрэн хангах боломжгүй.

Чухам үүнийг энд танилцуулж буй судалгааны үр дүнгээр баталж, гарц шийдлийг тодорхойлохыг зорив. Ингэхдээ БНХАУ-ын хүчин чармайлтаар хурдацтай өрнөж буй “Нэг бүс ба зам санаачилга”-д Монгол Улс хэрхэн оролцох, тус санаачилгын үр өгөөж, нийгмийн өнөөгийн амьдралд хэрхэн тусгалаа олж буй хийгээд түүний өмнө тулгарч байгаа саад бэрхшээл, гарц шийдлийг эл бичил судалгаагаар⁵ тодруулах оролдлого хийв. Тэрхүү тодруулгаа мөнхүү өгүүллийн хүрээнд гүйцэтгэсэн гуч гаруй өндөр түвшний шинжээчдийн дунд тусгайлан бэлтгэсэн шинжээчийн асуулгаар “Google Form” платформыг ашиглан цахимаар судалгааг цуглуулж, асуулт тус бүрээр

нэгтгэн боловсруулсан үр дүнг дараах байдлаар танилцуулж байна.

Дээр дурдсан судалгааны үр дүнгүүд нь “Бүс ба зам санаачилга”-ын эргэн тойронд суурь шалтгаан болсон үндэслэлүүд болох нь шинжээчдийн судалгаагаар илэрсэн юм. Харин дор харуулах судалгааны үр дүнгүүд нь “Бүс ба зам санаачилга”-ын хэрэгжилтийг цаашид хэрхэн сайжруулах, үр дүн, хэрэгжилтийг түргэтгэхэд чухал санаа, гарц шийдэл болох нь тодорхой харагдсан юм.

Тухайлбал, эл бичил судалгаанд хамрагдсан 60 орчим шинжээчдээс БНХАУ-ын санаачлан хэрэгжүүлж буй “Бүс ба зам санаачилга”-ын талаар ямар санаа бодолтой буйг тодруулсан асуултын хариултыг агуулгын шинжилгээ хийж багцлан эцсийн үр дүн бүхий илэрхийлэмжүүдийн түгээмэл илэрхийлэгдсэнийг энд танилцуулж байна.

1	ОЙЛГОЛТЫН ХУВЬД:	<ul style="list-style-type: none"> ○ Бүс нутгийн улс орнуудын дэд бүтэц, эдийн засгийн хөгжлийг уялдуулан хөгжүүлэх явдал; ○ БНХАУ-ын бүс нутгийн түвшинд гүйцэтгэж буй үүрэг ролийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн гадаад идэвхтэй бодлого; ○ Ер нь бол алсыг харсан зөв шийдвэр, бодлого; ○ Бүс нутаг, олон улсын тавцанд нөлөөний хүрээгээ тэлэх зорилготой бодлого, үйл ажиллагаа; ○ Энэхүү санаачилга нь Ази тив (нэн ялангуяа Хятад) эргэн дэлхийн эдийн засаг, улс төр, соёл, шинжлэх ухааны төв болох том амбицыг илтгэдэг; ○ Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн санаачилга; ○ Эергээр ойлгодог, гэхдээ одоогоор хүрэх үр дүнг сайтар төсөөлдөггүй;
---	------------------	--

⁵ О.Хатанболд. “Нэг бүс, нэг зам санаачилга ба Монгол Улс: нөхцөл байдал, шалтгаан, гарц шийдэл” сэдэвт бичил судалгаа. УБ., 2023 он

2	<p>Үйл ажиллагааны хувьд:</p>	<ul style="list-style-type: none"> ○ Одоогоор төдийлөн хэрэгжилт хангалттай биш, гэхдээ хятадын талаас Бүс ба замын философийг сурталчлах үйл ажиллагааны сувгуудыг сайн ашигладаг; ○ Энэ бол Хятадын мега төсөл бөгөөд үүнд хэдэн арван улсыг оролцуулахаар төлөвлөж байна; ○ Эдийн засаг, нийгмийн янз бүрийн салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хангахын тулд хүчин чармайлтаа нэгдмэл байдлаар нэгтгэх; ○ Нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин доогуур хил орчмын нутаг дэвсгэрийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх боломжтой; ○ Олон улс хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа сайжрах боломжтой; ○ Монголын хувьд дэлхийн газар нутаг энэхүү түүхэн боломжийг сайтар ашиглах ёстой. ○ Зөв ашиглаж чадвал өгөөж хүртэж болно, гэвч улс төрчдийн сөрөг ашиг сонирхол шингэтэл алсдаа хэд өндөр үнэ төлж магадгүй;
---	--------------------------------------	---


Бүс ба зам санаачилгад манай улс дүнд гарсан илэрхийлэмжийг багцлан нэгдэн орсноор ямар үр дүнд хүрнэ гэж шинжилсний дүнд дараах саналууд үздэгийг шинжээчдийн судалгааны үр нийтлэг ажиглагдсан юм.

1	<ul style="list-style-type: none"> - Монгол Улс энэхүү санаачилгад нэгдэн орсноор юуны өмнө бүс нутгийн дэд бүтэц, түүний дотор эрчим хүчний, зам харилцааны нэгдсэн сүлжээнд нэгдэн орох боломж нээгдэх онцгой ач холбогдолтой.
2	<ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн ач холбогдлын хувьд, худалдаа, дэд бүтэц, эрчим хүч, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих; - Монгол Улсын төр засгаас баримталж буй гадаад харилцаа, худалдааны бодлогын тэнцвэрийг хадгалах;
3	<ul style="list-style-type: none"> - Цаг тулгасан богино хугацааны улс төрийн шийдвэрээр бус алсын хараатай, урт хугацааны төлөвлөлттэй бодлогыг боловсруулахад чухал үүрэгтэй; - Урт хугацааны хөгжлийн стратеги, түүний хэрэгжилтийн үе шатуудтай холбох; - Салбар хоорондын уялдааг хангасан ухаалаг удирдлагын арга барилыг нэмэгдүүлж, үр дүнд суурилсан үр өгөөжийг хүртэх;
4	<ul style="list-style-type: none"> - Төсөлд хамрагдсанаар хүн амын амьжиргааны түвшин дээшилнэ; - Төмөр зам, авто замын сүлжээнд нэгдэх орох, дэд бүтцийн шинэчлэл хийх; - Гадаадын хөрөнгө оруулалт (лагчид)-ыг татах; - Монголын аж ахуйн нэгжүүд олон улсын түвшинд гарах боломжийг нээх; - Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх; - Дэд бүтцийн тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд таатай боломж бүрдэхэд зэрэгт эергээр нөлөөлнө.

5	<ul style="list-style-type: none"> - Бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэнээр тус бүс нутаг дахь БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн үр өгөөжөөс хүртэх боломж бүрдэнэ. - Санаачилгад нэгдэн орсны үр дүн, үр ашгийн тооцооллыг тогтмолжуулж, үндэсний эдийн засагт оруулах ач тус, нөөцийг зохистой зарцуулах, шинэ боломжуудыг нэмэгдүүлэх; - Геополитикийн ач тус, ижил бүсийн улс орнуудын хөгжил, нөлөөлөлд өөрийн улсын байр суурийг илэрхийлэх боломжтой;
6	<ul style="list-style-type: none"> - Хяналт, удирдлагын тогтолцоог сайжруулах, энэ чиглэлийн дэд бүтцийг төлөвшүүлэх; - Соёл хоорондын харилцан хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, итгэлцлийн түвшнийг дээшлүүлэх; - Хил залгаа байрладаг улсын хувьд эл санаачилгад нэгдэн орсноор далайд гарцгүй, бараа, худалдааны хувьд бараг бүрэн хараат улсын хувьд эдийн засгийн эргэлтэд эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой.
7	<ul style="list-style-type: none"> - Улс төрийн бодлого, эдийн засгийн зөв бодлого барихгүй бол хэт их өрөнд орох эрсдэлтэй. Одоогоор 138 улс нэгдэн орсон энэхүү санаачилгын үр ашгийг хүртэж байгаа улс байхад, зөвхөн тухайн улсаас авсан зээл нь дангаараа ДНБ 20%-тай тэнцэж буй улс байгааг ямагт анхаарч байх.

Бүс ба зам санаачилгыг хэрэгжүүлснээр манай улсын аль салбарт илүү үр өгөөжтэй болохыг шинжээчдээр үнэлүүлж, үр дүнг нэгтгэн дүгнэв. Чингэхэд, тэдний дийлэнх нь тээвэр логистик, эдийн засгийн хөгжил, уул уурхай, олборлох үйлдвэрийн болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хамгийн их үр өгөөж үзүүлнэ хэмээн нийт судалгаанд хамрагдсан (60/44) шинжээчдийн 73 хувь нь үзсэн байна.

Зураг 3. Бүс ба зам санаачилгыг хэрэгжүүлснээр манай улсын аль салбарт илүү үр өгөөжтэй эсэх талаар шинжээчдийн өгсөн үнэлгээ




Зурагт шинжлэх ухаан боловсрол, үйлчилгээний ба жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт үр өгөөж бага хэмээн судалгаанд хамрагдсан нийт (60/23) шинжээчдийн 53.3% үзсэн нь харагдана. Харин хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэлийн болон бусад салбаруудад мэдэгдэхүйц хэмжээний үр өгөөж ажиглагдахгүй хэмээн (60/9) шинжээчдийн 15 хувь нь үзжээ. Нийт судалгаанд хамрагдсан шинжээчдийн (60/16) 26 хувь нь үүнийг “огт үр дүнгүй” хэмээн үнэлсэн байна. Үүнээс гарах нэг чухал дүгнэлт бол олон улсын зам тээвэр, худалдаа арилжаа, техник технологийн дэвшлээс хуваалцах, шинэ Евроазийн коридор байгуулагдах эдийн засгийн том үр өгөөж харагддаг. Төв Азийн улс орнуудтай ялангуяа БНХАУ, ОХУ-тай ачаа тээврийн салбарт илүү холбогдох байх. Зөв бодлого хэрэгжүүлэхгүй бол боловсруулах салбар сэргэхээс илүүтэй

устах, түүхий эдийн экспортлогч улс болох эрсдэл өндөр байна.


“Бүс ба зам санаачилга” нь Монгол Улсын урт хугацааны хөгжилд ямар ач холбогдолтой эсэхийг тодруулсан асуултад шинжээчдийн 47.8 хувь “дунд зэрэг ач холбогдолтой”, 39.4 хувь нь “хамгийн их ач холбогдолтой”, 13 хувь нь “огт ач холбогдолгүй” хэмээн үзсэн байна. Үүнээс улбаалан “Бүс ба зам санаачилга” нь бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагаа болон түүний хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах боломжийг хэрхэн бүрдүүлж буйг 5 хүртэлх шкалаар үнэлүүлэхэд дараах дүр зураг ажиглагдав. Тодруулбал, шинжээчдийн 39.8 хувь нь “Бүс ба зам санаачилга” бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагаанд дорвитой хувь нэмэр оруулсан гэж үзсэн бол, 39.1 хувь нь “дунд”, 21.8 хувь нь “хамгийн муу” хувь нэмэр оруулсан гэж үзсэн байна.

Зураг 4. “Бүс ба зам санаачилга” бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагаанд оруулж буй хувь нэмэр (1 хамгийн сайн, 5 хамгийн муу)

Монгол Улсын урт хугацааны хөгжилд үзүүлэх ач холбогдолын хувьд:



Бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагаа, түүний хөгжилд оруулах бодит хувь нэмэр, боломжийн хувьд:




“Бүс ба зам санаачилга” нь Монгол Улсын хөгжилд хүндрэл учруулах

эрсдэлтэй эсэх талаар санал нийлж буй тодруулсан эрсдэлийг тодруулахад

судалгаан хамрагдсан шинжээчдийн хандсаныг доорх зургаас харч болно хувьд эл асуудалд 50:50 байр сууринаас (Зураг 5).


Зураг 5. “Бүс ба зам санаачилга” нь Монгол Улсын хөгжилд хүндрэл учруулах эрсдэлтэй эсэх



Дээрхийг лавшруулан эрсдэлийг нарийн тооцон гаргахыг зорив. Чингэхдээ судалгаанд хамрагдсан шинжээчдээр Монгол Улсын хувьд эл санаачилгад нэгдэн орж, тодорхой төслүүдийг хэрэгжүүлснээр ямар эрсдэлүүд учирч болзошгүй талаар тэдний төсөөллийг гаргав. Ингэхэд дараах дүр зураг ажиглагдсан юм. Үүнийг тодруулбал, шинжээчид хамгийн их эрсдэлтэй хэмээн улс төрийн, аюулгүй байдлын эдийн засгийн эрсдэлүүдийг голчлон нэрлэсэн юм.

Тэдгээр нь тухайн дурдсан эрсдэлүүдээс 21.6 хувийг эзэлж байна. Харин тааварлах боломжгүй эрсдэлүүдэд шинжээчдийн 15 хувь нь эрх зүйн, ёс суртахууны эрсдэлүүдийг тооцон оруулсан байна. Мөн аюулгүй байдлын эрсдэлийг тааварлах боломжгүй хэмээн үзжээ. Дурдсан эрсдэлүүдэд дундаж утга үүсгэн индексжүүлэхэд тэдгээр эрсдэлүүдээс аюулгүй байдал, эдийн засаг, эрх зүйн эрсдэлүүдийг нийт судалгаанд хамрагдсан (60/18) шинжээчдийн 28.8 хувь нь үнэлсэн.

Зураг 6. “Бүс ба зам санаачилга”-д нэгдэн орсноор Монгол Улсын хувьд учирч болзошгүй эрсдэлүүд (салбараар)



Дээр дурдсан эрсдэлүүдийг Ингэхэд шинжээчдийн хариултыг шийдвэрлэхийн тулд ямар үйл ангилал үүсгэн нэгтгэн багцалвал ажиллагааг идэвхтэй авч хэрэгжүүлбэл дараах илэрхийлэмжүүд нийтлэг зохистой талаар шинжээчдээс хөндөгдсөн болно. тодруулж үр дүнг нэгтгэхийг зорив.


1	- эдийн засгийн хараат байдлыг нэмэгдүүлэхийг аюултай гэж үзвэл санаачилгын хүрээнд Монгол Улсад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг ҮАБЗ-ийн хэмжээнд хатуу тохирч, нэгдсэн шийдвэрт хүрсэн байх шаардлагатай.
2	- Үндэсний соёл, түүх, хэлний дархлааг дэмжих; - Санаачилгад идэвхгүй хэрэглэгч бүхий дагагч бус идэвхтэй оролцогч, үйлдвэрлэгч, бүтээгч байх нь чухал. - Төрөөс бус хувийн хэвшлийг дэмжсэн оролцоог нэмэгдүүлэх нь чухал.
3	- Улс төр, иргэдийн ойлголт, мэдээллийн орчин, үндэсний аюулгүй байдал, хөрөнгө оруулалтын аюулгүй байдал, нөөцүүд зэрэг шаардлагатай бүхий л нөлөөллийг тооцсон бодлого, түүний хэрэгжилт/бодлогын түвшин салбар, салбар дунд бүрээр нарийн тооцоолж байх.
4	- Олон улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, эрсдэлийг бууруулахын тулд эхний шатанд холбогдох гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурах, хөршүүдтэйгээ тэнцвэртэй бодлогыг хангах шаардлагатай.
5	- Эдийн засгийн интеграцид нэгдэхдээ ямар тэргүүлэх чиглэлийг бусдаас давуу тал болгон баримтлах вэ буюу бүс нутгийн интеграцийн бусад улсууд Монгол Улс үгүйгээр цааш явах боломжгүй байх тэр салбар чиглэлийг тодорхойлох (газрын ховор элемент, уран гм),
6	- Хууль, эрх зүйн орчныг тодорхой, тогтвортой байлгахад анхаарах - Урьдчилсан тооцоо, судалгаа, нөлөөллийн үнэлгээ хийх - Монгол Улсын хувьд хүртэж болох өгөөж, гарч болох эрсдэлийг хамруулсан SWOT шинжилгээг хийхэд;
7	- Судалгаа шинжилгээ сайн хийх, нөлөөллийг бий болгох, алдахгүй байхад анхаарах,
8	- Төрийн бодлого тогтвортой байх, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, төрийн албаны дунд шатанд дахь албан хаагчдын чадавхжуулах, хариуцлагажуулах,
9	- Гадаад бодлогын маш сайн мэргэжилтэнтэй байх, тэдгээрийн санаа бодлыг сонсох хэрэгтэй. Хөрш орон судлалыг Монгол улсад тусгайлан хөгжүүлэх,
10	- Оролцоогоо нарийвчлан тодорхойлох, Монгол улсад бий болох эрсдэл, ач тусыг төсөл болгоноор тооцоолон үнэлэх,

Дээр дурдсан илэрхийлэмжид шинжилгээ хийж, “Бүс ба зам санаачилга” манай улсад идэвхтэй, үр өгөөжтэй хэрэгжихгүй байгаагийн гол шалтгааныг шинжээчдийн өгсөн доорх хариултаар тайлбарлаж болохоор байна. Тодруулбал, шинжээчдийн 65

орчим хувь нь тус санаачилга ийнхүү үр өгөөжтэй, идэвхтэй хэрэгжихгүй байгаагийн гол шалтгааныг улс төрийн байдлаас, эдийн засгийн чадамж, мөн талуудын харилцан ойлголцол, илтгэлцэлээс болон хүний нөөцийн чадамжаас үүдэлтэйгээр идэвхтэй

хэрэгжихгүй байна хэмээн үзсэн.

Зураг 7. “Бүс ба зам санаачилга” манай улсад идэвхтэй, үр өгөөжтэй хэрэгжихгүй байгаагийн гол шалтгаан



“Бүс ба зам санаачилга”-ыг хэмжээг авч хэрэгжүүлбэл зохистой Монгол Улсын урт хугацааны бодлого талаар бид шинжээчдээс тодруулав. «Алсын хараа 2050»-д нийцүүлэх Ингэхэд дараах байр сууриуд нийтлэг замаар өөрийн орны хөгжлийн илэрхийлэгдсэн болно. Тэдгээрийг түвшнийг ахиулахад ямар арга багцлан үзүүлбэл:


1	- Түлш, эрчим хүчний нэг орноос хараат байдлаас гарахын тулд нүүрсний болон сэргээгдэх эрчим хүчний 2-3 Мега төсөл хэрэгжүүлж, дотоодын хэрэгцээг хангаад зогсохгүй, эрчим хүчийг Бүс нутгийн сүлжээнд холбох эхлэлийг тавих,
2	- Далайд гарцгүй орны хувьд Бүс нутгийн орнуудтай холбогдох, далайд гарах, Европ хүрэх дөт замыг нээхийн тулд төмөр замыг хос замтай болгон шинэчлэх, цахилгаанжуулах, авто замын хувьд олон улсын стандартад нийцсэн хурдны босоо тэнхлэгийн замыг яаралтай байгуулах,
3	- ХАА болон ЖДҮ-ийн үндэсний бүтээгдэхүүнийг Бүс нутгийн зах зээлд гаргах бодлогыг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай тээвэр, ложистикийн дэд бүтцийг нэгдсэн журмаар шийдвэрлэж өгөх,
4	- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, авлига, албан тушаалын гэмт хэргийг арилгах, бодлогын залгамж чанараа хадгалах, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааг бодлогын түвшинд түлхүү авч хэрэглэх нь чухал
5	- Ардчилсан нийгэмд хүний эрх нэгдүгээрт тавигдах ёстой. Хоёр төслийг харьцуулахдаа Монгол Улс өөрсдөдөө ашигтай байх ёстой. Улс орон, хүний нөөц бололцоог хөгжүүлэхийн тулд хоёр төсөл бие биеэ харилцан баяжуулах ёстой.
6	- Бие биеэ хүндэтгэж, хамтран ажиллах нь төслийн хэрэгжилтийг чанарын түвшинд хангах ёстой. Монгол Улс хөрөнгө оруулалтын итгэлийг олон улсын түвшинд нэмэгдүүлж, төсөл хэрэгжүүлэх боловсон хүчнийг чанарын өндөр түвшинд бэлтгэж, төвийг сахих бодлогыг үргэлжлүүлж,

7	- Бүс ба зам санаачилгын хөтөлбөр, төлөвлөгөө, үйл ажиллагааг мэдэхгүй тул асуултад хариулахад хүндрэлтэй байна. Уг санаачилгын талаар сонссон, 3 орны чуулган хийдэг гэж мэддэг, өөр бодит санаачилга, түүний үр дүнгийнталаарх ойлголт сул байдаг.
8	- Эхний ээлжид эрчим хүч, уул уурхайн салбарт онцгой ач холбогдол өгч, боловсруулах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд анхаарах. Түүнчлэн баруун бүсээр Шинжаан уйгарын европ чиглэлийн төмөр замтай холбогдох

“Нэг бүс, нэг зам санаачилга ба Монгол Улс” сэдэв бичил шинжээчдийн судалгаанд хамрагдсан шинжээчдийн **насыг ангилан үзвэл**: 35-45 насныхан 37.5 хувь, 45-54 насныхан 43.8 хувь, 54-65 насныхан 12.5 хувь, 65-аас дээш насныхан 6.3 хувь байв. **Хүйсийн хувьд** судалгаанд хамрагдсан шинжээчдийн

62.5 хувь эрэгтэй, 37.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Боловсролын хувьд эл бичил судалгаанд хамрагдсан шинжээчдийн 93.8 хувь нь дээд боловсролтой, 6.3 хувь нь мэргэжлийн дипломын боловсролтой хүмүүс оролцсон болно.

Зураг 8. “Нэг бүс, нэг зам санаачилга ба Монгол Улс” судалгаанд хамрагдсан шинжээчдийн хөдөлмөр эрхлэлт, ажилласан хугацаа



Шинжээчдийн эрхэлдэг ажил болон тухайн салбартаа ажиллаж буй хугацаагаар нь авч үзвэл: эл судалгааны зорилго, чиглэлтэй шууд хамааралтай болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг эрдэмтэн судлаачид, эрдэм шинжилгээ-боловсролын байгууллагуудын төлөөлөл 28.3 хүртэлх хувь, төрийн байгууллага, улс төрийн албан тушаалтнууд 15

хүртэлх хувь, бизнесийн болон хувийн салбарын төлөөлөл 16.6 хувь, олон улсын байгууллага болон иргэний нийгэм-төрийн бус байгууллагуудын төлөөлөл 16.6, бусад буюу жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, улс төрийн намуудын төлөөлөл, хувиараа бизнес эрхлэгчдийн төлөөллүүдээс 23.5 хувь хамрагдав.

Дүгнэлт

Монгол Улс нь газар зүйн хувьд Орос, Хятадын дунд оршдог далайд гарцгүй орон. Энэ утгаараа Монгол Улсын гадаад бодлого ч зарим талаараа эл нөхцөл байдлаар тодорхойлогдож ирсэн нь түүхийн хуудаснаас бэлхнээ харагдана. Тухайлбал, Монгол Улс нь социалист тогтолцооны үед бусад социалист лагерийн улс орнуудын нэгэн адил хойд хөрш Зөвлөлт Холбоот Улсын удирдлага, зааварчилгаа дор төрийн бүхий л үйл хэрэг хийгээд гадаад бодлогын хувьд ч шууд хамааралтай байсаар ирсэн түүхтэй. Харин социалист блок задран унасны дараа Монгол Улс ардчилал, шинэчлэлийн замыг тууштай сонгож, улмаар өөрийн орны гадаад бодлогодоо эрс шинэчлэл хийсэн юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улс социалист блок задран унасны

дараагаар улс орныхоо гадаад бодлогын хэлхээ холбоог үлэмж өргөжүүлж ирсэн нь хуучин ЗХУ, одоогийн ОХУ руу чиглэсэн нэг талыг баримталсан хандлагаас татгалзаж, өөрийн орны гадаад бодлогодоо хандах хандлагаа эрс өөрчилж чадсан гэж болно.

Улмаар БНХАУ болон дэлхийн бусад улстай харилцаагаа хөгжүүлж эхэлснээр олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг бүрдүүлэх гол үндэс болсон. Монгол, Хятад хоёр улс эрт дээр үеэсээ эдийн засаг, түүх, соёлын харилцаатай явж ирсэн хөршүүд. Энэ ч утгаараа, хоёр улсын хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд улс төр, нийгэм, эдийн засгийн болон бусад бүх хүрээнд харилцан ашигтайгаар өрнөж тэр дундаа худалдаа, хөрөнгө оруулалтын салбарт эрчимтэй өргөжиж байна.



Хятадын философитой шууд холбогдох «эв нэгдэлтэй байх, олон талт байдлыг хүндэтгэх» хэмээх ойлголт буюу монголчуудын хэлдгээр «арга, билэг»-ийн шүтэлцээ, түүний тэнцвэртэй байдал нь дэлхий дахинд энх тайван, амар амгалан байж гэмээ нь

улс үндэстэн хоорондын дайсагналыг арилгаж, зохистой, шударга хамтын харилцааг өргөжүүлснээр улс орон бүрд оршин амьдарч буй гэр бүлүүд, хамтран ажиллагсад, улс үндэстнүүдийн хоорондын харилцаа улам бүр батжин хөгжих үндэс суурь болно. Тэгэхээр

чадавхыг бэхжүүлэх нь нийгмийн бүх түвшинд хөгжлийн асуудалд суурь хэрэгцээг хангахаас гадна байгууллагын болон олон нийтийн хөгжил нь эдийн засгийн хөгжлийг хамардаг суурь зарчим бүхий нийгмийн зохион байгуулалт юм. Өөрөөр хэлбэл, иргэн бүр өөрийн өмнө тулгарч буй аливаа асуудлыг тодорхой, оновчтой байдлаар үзэл бодлоо ардчилсан аргаар илэрхийлэх нь аливаа сөрөг үйл явдлуудын бодитоор олж харах боломжийг олгож болно.

Эцэст нь дүгнэвэл, бид хөгжлийг эрх чөлөө гэж ойлгохыг хүсвэл хүмүүн капиталын хязгаарлагдмал үзэл баримтлалын хүрээнээс зайлшгүй гарах ёстой болохыг ухаж таних нь зүйтэй. Үүний нэгэн илрэл бол Хятад, Монголын

Засгийн газар хоорондын эдийн засаг, худалдаа, технологийн хамтарсан хороо, ашигт малтмал, эрчим хүчний харилцан уялдаатай хамтын ажиллагааг ашиглан талуудын эрчимжүүлж, хоёр талын худалдааны цар хүрээг өргөжүүлэх, ашигт малтмалын нөөцийг хөгжүүлэх, хот суурин газрын шинэчлэлт, хүмүүнлэгийн чиглэлээр хамтрах боломжийг бүрдүүлэх нь хөрөнгө оруулалтын суурь нөхцөл болно. Үүний тулд бид худалдааны бүтцийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гаалийн бүрдүүлэлтийн чадварыг сайжруулах, уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааг төрөлжүүлэх шаардлагатай байна.

Ном зүй

1. 2022 оны байдлаар Улаанбаатар хотод 1596.3 иргэн буюу нийт иргэдийн 45 хувь нь оршин суудаг. <http://ubstat.mn/StatTable=20>
2. ШУА. Философийн хүрээлэн. Зүүн Европын улс орнууд болон монголын ардчилал: ололт, амжилт, сорилт бэрхшээл. ОУЭШХ. Илтгэлийн эмхэтгэл. 2022 он, Улаанбаатар хот
3. О.Хатанболд. Монгол Улс дахь шашны хэтийн хандлага. Эрдэм шинжилгээний хэлэлцүүлэгт хэлэлцүүлсэн илтгэл. ЕТГ., ҮАБЗ. Төрийн ордон, 2018 оны 4-р сарын 17-ны өдөр. Улаанбаатар хот
4. ШУА. Философийн хүрээлэн. Евроазийн бүс нутаг дахь Монгол, Оросын соёлын иргэншлийн харилцааны үйлчлэл. Хамтын бүтээл. ред. Г.Чулуунбаатар, А.С.Железняков, О.Хатанболд. Соёмбо принтинг ХХК. 2023. Улаанбаатар хот
5. О.Хатанболд. “Нэг бүс, нэг зам санаачилга ба Монгол Улс: нөхцөл байдал, шалтгаан, гарц шийдэл” сэдэвт бичил судалгаа. 2023 он, Улаанбаатар хот

The Belt and Road Initiatives & Mongolia: Expert survey results

Khatanbold Oidov

Ph.D

*Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia
khatanboldo@mas.ac.mn*

Abstract: *Since 1990, Mongolia has been moving from a planned economy to a market economy, revolutionizing social order, and adopting democratic methods for more than 30 years. During this period, dozens of studies on the social, economic and political development of Mongolia made specific assessments and conclusions. The articles are aimed at Mongolia’s development, characteristics, and participation in the Belt and Road Initiative, which is launched by the People’s Republic of China, its advantages, the impact on the current state of Mongolia’s society, and the obstacles it faces. The paper presents the results of research divided into four main groups: common ground, cause-effect, solution-effect and conclusion.*

Keywords: *Mongolia, China, Belt and Road Initiatives, experts, tradition and assessment*

The day of submission: 2023.11.02

Completion of review: 2023.11.10

Final decision for acceptance: 2023.12.01